



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 25 өдөр

Дугаар A/52

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг орон нутгийн хөгжил цэцэглэлт, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж Шим-Ус Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бактерлогич М.Жаргалсайхан, Хөгжил политехник коллежийн эдийн засгийн багш Д.Дуламсүрэн, нягтлан бодогч Н.Жавзанханд нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан М.Жаргалсайхан, Д.Дуламсүрэн, Н.Жавзанханд нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг дээрх байгууллагуудын дарга нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 00253 Zax A/52.Ch